

БАТЛАВ:
БЗӨБЦТС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д. Х. ГАНЧУЛУУН

2025 оны 05 сарын 06 өдөр

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА,
ТӨЛБӨРИЙН АКТЫН МӨРӨӨР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Албан шаардлага, зөвлөмж, төлбөрийн акт	Хийгдэх ажил	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хяналт тавих албан тушаалтан
Зөвлөмж					
1	Сургалтын тайлан, гүйцэтгэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийсэн. (Дорноговь салбар 19.0 сая төгрөг, Говьсүмбэр салбар 3.0 сая төгрөг)	Сургалтын тайлан, анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлэх. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.	Цаашид	Говьсүмбэр, Дорноговь ЦТССалбарын дарга, Ерөнхий инженер, Ахлах нягтлан бодогч нар	Хяналт хариуцсан менежер
2	Сэлбэг, аюулгүй байдлын хөрөнгө хадгалах агуулахгүйгээс 790.0 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан. (Төв компани)	2025 онд гадна агуулах барих ажлын зургийн тендер зарлахаар төлөвлөн ажиллаж байна. 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж барилга угсралтын ажлыг эхлэх төлөвлөгөөтэй байгаа.	2025, 2026 онд	ТҮАХБХэлтсийн дарга, ТЭЗХэлтсийн дарга	Ерөнхий инженер, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга
3	Контент хийлгэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хангуулаагүй.	Эрчим хүчний хэмнэлттэй үр ашигтай, зүй зохистой хэрэглээний дадал зуршлыг бий болгох, Эрчим хүчний тухай хууль, хуулийг сурталчлах зорилго бүхий видео шторкыг "Шинэшаяне" ХХК"-аар №24/01 дугаар бүхий ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн. Тус компанийн хийсэн видео шторкуудаас мэргэжлийн хэллэг зөрүүтэй болон дуу дүрсний нийлэмжгүй хэсгүүд байсан тул засварлах шаардлага тавьж, хугацаанд нь аваагүй болно. "Шинэшаяне" ХХК нь дээрх зөрчлүүдийг засварлан хүлээлгэж өгсөн. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар онцгойлон анхаарч ажиллана.	Цаашид	Бүтээмж хариуцсан менежер, ХААХАлбаны дарга, ХҮАХБХэлтсийн дарга	Хяналт хариуцсан менежер
4	Тайлант онд ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршуулсан 343.3 сая төгрөгийн компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийг өөрийн байгууллага дээр	2025 Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийхдээ цахим дэлгүүрт байршуулсан бараа материалаас худалдан авалт хийх ажлыг зохион байгуулах. Цаашид алдааг давтан гаргахгүй ажиллах.	Цаашид	ХААХАлбаны дарга	Хяналт хариуцсан менежер
Албан шаардлага					
1	Спортын арга хэмжээнд нийт 197.3 сая төгрөгийг төлөвлөснөөс 19.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.	Цаашид	ЗХНХэлтсийн дарга, СБХэлтсийн дарга, ТЭЗХэлтсийн дарга	Төлөвлөлт, маркетинг хариуцсан менежер
2	Тайлант онд шинээр авсан Ланд круйзер LC78 маркын автомашиныг ашиглах боломжгүй нөхцөл үүссэн боловч даатгалаас болон бусад байдлаар хохирол барагдуулах арга хэмжээ аваагүй байна. (Говьсүмбэр салбар)	Ланд круйзер LC78 маркын автомашины хохирлыг барагдуулж ажиллах талаар компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс хяналт тавьж Говьсүмбэр ЦТССалбарт үүрэг даалгавар өгч ажиллах.	6 сарын 15-ны дотор	Говьсүмбэр ЦТСС-ын дарга, Ерөнхий инженер	Ерөнхий инженер, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга
3	Байгууллагын үндсэн ажилтны хувийн компаниас шууд худалдан авалт хийсэн. (Говьсүмбэр салбар)	Худалдан авалтын төлөвлөгөөний дагуу салбарт эрх шилжүүлсэн худалдан авалтыг салбарын дарга нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.	Цаашид	Говьсүмбэр ЦТСС-ын дарга	Хяналт хариуцсан менежер, ХААХАлбаны дарга

4	Тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй	Байдлаг дэд станц, Луус дэд станцын хашаа барих ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэслэлгүйгээр анх батлагдсан тоо хэмжээг бууруулсан ч төсөвт өртгийг бууруулалгүй анхны батлагдсан төсөвт өтгөөр худалдан авалт зохион байгуулсан. Тендерийн баримт бичиг боловсруулахдаа ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичгийг ашиглаагүй. Бараа материал худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендерийг зохион байгуулсан.	2025 онд бүх тендерийн баримт бичгийн батлагдсан төсөв, тоо хэмжээ зэргийг хуулийн зөвлөх болон хяналт хариуцсан менежерээр хянуулж ажиллах. Тендерийн баримт бичгийн анх батлагдсан төсөвт өртөг, тоо хэмжээг өөрчлөх зөрчил давтан гаргахгүй ажиллах	Цаашид	ХААХАлбаны дарга, Үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичиг	Хяналт хариуцсан менежер
		Тэвштэй авто краны тендерт шалгаруулсан компани нь үйл ажиллагааны чиглэл нь тохирохгүй, ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага байхгүй. Тендерийн баримт бичигт ижил төрлийн гэрээний мэдээлэл ирүүлэх тухай үнэлгээний хороо заагаагүй. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай үнэлгээний хороо нь хуралдаж шийдвэрлээгүй.	Үнэлгээний хороонд ажиллах эрх олгох АЗ гэрчилгээ эзэмших сургалтыг компани дээр зохион байгуулж нийт 25 ажилчид шинээр хамрагдсан. Цаашид үнэлгээний хороонд ажиллах гишүүн, нарийн бичиг, дарга нарт тендерийн баримт бичиг боловсруулах тухай мэдээллээр хангаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан ажиллах талаар хяналт хариуцсан менежер заавар зөвлөгөө өгч ажиллана. Мөн жил болгоны сургалтын төлөвлөгөөнд худалдан авах ажиллагаатай холбоотой сургалтын зардлыг батлуулж нийт ажилчдыг хамруулж ажиллахаар төлөвлөж байна.	Цаашид	ХААХАлбаны дарга, Үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичиг	Хяналт хариуцсан менежер
		Эрүүл монгол хөтөлбөртэй давхардуулж үйл ажиллагааны чиглэл тодорхой бус компанитай гэрээ байгуулан ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан, төсвийг үрэлгэн зарцуулсан.	2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан асуудал нь "Алсын хараа 2050" болон "Эрүүл Монгол иргэн" хөтөлбөртэй давхцсан байна гэсэн зөвлөмжийг хүргүүлж байгаа нь дараах заалтуудыг зөрчиж, хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах ажил олгогчийн эрх үүргийг хангаж чадахгүй эрсдэл бий болж байна. Үүнд: 1. Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн туха хуулийн 14 дүгээр зүйл, 26.5.2 дугаар заалт; 2. Эрчим хүчний сайдын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 10 дүгээр тушаалаар батлагдсан "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 17 дугаар заалт; 3. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны 340 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам"-ын 4.4, 7.7 дахь заалтууд; 4.Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.24, 44.1.6 дахь заалтууд; 5.Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйл. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг нь эрүүл мэндийн салбарт хэрэгжих төсөл хөтөлбөрийн хүрээнд бус хуулиар тусгайлан заасан эрх үүргээр хэрэгжсэн ажил болно.		ХААХэлтсийн дарга, ХААХАлбаны дарга, Үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичиг	Хяналт хариуцсан менежер

Төлбөрийн акт						
1	Тайлант онд дүрэмт хувцас худалдан авах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж худалдан авсан.	Төлбөрийн актаар тогтоосон 27,234,000 (хорин долоон сая хоёр зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГазрын хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.	2025.04 сар		СБХэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, ТЭЗХ-ийн дарга, ЗХНХэлтсийн дарга, ХААХАлбаны дарга	Хяналт хариуцсан менежер. ХААХэлтсийн дарга
			Цаашид			

Хянасан:

Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий
нягтлан бодогч Т.Болдсанаа



Төлөвлөгөө нэгтгэсэн:

Ахлах нягтлан бодогч



Т.Оюун-Эрдэнэ